



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 08 өдөр

Дугаар А/63

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалт, 43 дугаар зүйлийн 43.1.6 дахь заалт, 122 дугаар зүйлийн 122.1, 122.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн Хөдөлмөрийн дотоод журмыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Хөдөлмөрийн дотоод журмыг нийт албан хаагчдад танилцуулж, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, маркетингийн албаны дарга (Ч.Батболд)-д даалгасугай.
3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Ерөнхий захирлын 2022 оны А/23 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ  Н.ЭРДЭНЭБАЯР

